

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/40/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	3
Хүснэгтийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Залруулсан алдаа	21
5.2 Төлбөрийн акт.....	22
5.3 Албан шаардлага	22
5.4 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	24
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	24
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	15
Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	20

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/151
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ нь Досей ХХК-иар сургуулийн байрны 19,500.0 мянган төгрөгийн зураг төсвийг орлогод авалгүй зардал дансанд бичиж хаасан байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 589,324.0 мянган төгрөгийн өртөгтэй 1025 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

G/Архив/Албан бичиг 2023/ А4
19020285

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,619,946.66	233,588,496.66
33	АВЛАГА	23,000,000.00	159,000,000.00
335	Бусад авлага	23,000,000.00	159,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	23,000,000.00	159,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	63,619,946.66	74,588,496.66
354	Хангамжийн материал	63,619,946.66	69,588,496.66
35420	Аж ахуйн материал	48,219,946.66	69,588,496.66
35470	Бусад хангамжийн материал	15,400,000.00	0.00
35600	Мал амьтад	0.00	5,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,845,700,113.91	10,026,909,109.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,845,700,113.91	10,026,909,109.59
392	Биет хөрөнгө	10,790,766,002.44	9,972,181,109.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,567,601,682.37	1,694,929,589.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	-565,475,240.05	-675,431,483.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	252,173,600.00	446,252,332.59
39204	Хуримтлагдсан элэгдэл	-173,377,139.19	-211,922,817.51
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	165,781,520.00	204,146,270.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,475,926.03	-123,078,431.77
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,835,077.00	59,586,265.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,139,109.32	-47,324,382.67
39209	Зам, гүүрийн байгууламж	10,674,041,626.00	10,674,041,626.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-1,198,079,849.27	-2,249,045,648.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	230,731,534.00	319,551,133.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-98,669,973.07	-141,341,542.79
39217	Ном	21,818,200.00	21,818,200.00
393	Биет бус хөрөнгө	54,934,111.47	54,728,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	64,328,000.00	64,328,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-9,393,888.53	-9,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,932,320,060.57	10,260,497,606.25
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,932,320,060.57	10,260,497,606.25
51	Засгийн газрын хувь оролцоо	10,932,320,060.57	10,260,497,606.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	733,779,241.53	733,779,241.53
51101	Өмч: - төрийн	733,779,241.53	733,779,241.53
512	Хуримтлагдсан үр дүн	9,816,980,667.11	9,145,158,212.79
51210	Өмнөх үеийн үр дүн	9,816,980,667.11	9,816,980,667.11
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-671,822,454.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	381,560,151.93	381,560,151.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,932,320,060.57	10,260,497,606.25

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	92,117,890.04	396,078,051.19
120	Нийтлэг татварын бус орлого	92,117,890.04	396,078,051.19
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92,117,890.04	396,078,051.19
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	92,117,890.04	396,078,051.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	664,706,627.70	827,914,794.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,148,627.70	329,731,494.47
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	80,750,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	100,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,290,750.00	170,924,936.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,107,877.70	58,806,558.47
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	507,558,000.00	498,183,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	507,558,000.00	498,183,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,839,008,123.62	1,893,568,213.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,833,018,123.62	1,872,434,291.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,779,794,245.49	1,758,743,414.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,217,100.00	258,723,361.73
210101	Үндсэн цалин	177,591,043.00	197,230,127.74
210102	Нэмэгдэл	48,025,000.00	34,462,206.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	342,000.00
210104	Урамшуулал	-	22,513,570.50
210105	Гэрээт ажлын хөлс	37,601,057.00	4,175,456.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,440,037.03	35,795,066.65
210201	Тэтгэврийн даатгал	23,888,837.99	25,534,000.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,637,949.76	2,566,891.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,374,039.44	2,099,502.49
210204	Ажилгүйдлийн даатгал	659,609.81	529,874.04
210205	Эрүүл мэндийн даатгал	4,879,600.03	5,064,798.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,642,053.91	57,555,370.50
210301	Гэрэл, цахилгаан	11,177,645.91	14,511,868.00
210302	Түлш, халаалт	45,214,408.00	42,793,502.50
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	54,233,984.63	35,152,788.00
210401	Бичиг хэрэг	4,545,810.00	1,781,050.00
210402	Тээвэр, шатахуун	32,093,687.00	26,607,528.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,207,619.63	3,644,210.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,657,400.00	3,120,000.00
210408	Бараа материал акалсны зардал	11,729,468.00	-
2105	Нормативт зардал	700,602.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	700,602.00	-

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,312,900.00	10,147,000.00
210604	Урсгал засвар	5,312,900.00	10,147,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,258,000.00	3,092,600.00
210702	Дотоод албан томилолт	2,258,000.00	3,092,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,544,048.70	15,307,769.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,096,375.70	13,796,366.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	497,475.00	304,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	353,198.00	609,978.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,331,445,519.22	1,342,969,458.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,148,216.30	78,997,090.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,235,297,302.92	1,263,972,368.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,223,878.13	113,690,876.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,024,900.00	63,225,498.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,037,700.00	8,486,347.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,987,200.00	54,739,151.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,198,978.13	50,465,378.23
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,990,000.00	21,133,922.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,990,000.00	21,133,922.00
220001	Барилга байгууламж	4,545,000.00	-
221001	Их засвар	846,000.00	-
223001	Бусад хөрөнгө	599,000.00	21,133,922.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,082,183,605.88)	(669,575,367.55)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	258,292,300.48	2,247,086.77
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,030,000.00	240,766.94
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	257,262,300.48	2,006,319.83
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(258,292,300.48)	(2,247,086.77)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,340,475,906.36)	(671,822,454.32)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	664,706,627.70	827,914,794.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	664,706,627.70	827,914,794.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,148,627.70	329,731,494.47
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	80,750,000.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	100,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,290,750.00	170,924,936.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,107,877.70	58,806,558.47
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	507,558,000.00	498,183,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	507,558,000.00	498,183,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	565,514,094.57	699,077,516.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	565,514,094.57	699,077,516.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	546,476,401.57	611,893,818.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,217,100.00	236,110,763.18
210101	Үндсэн цалин	177,591,043.00	179,920,037.07
210102	Нэмэгдэл	48,025,000.00	35,343,005.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	342,000.00
210104	Урамшуулал	-	20,505,721.11
210105	Гэрээт ажлын хөлс	37,601,057.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,440,037.03	30,039,200.00
210201	Тэтгэврийн даатгал	23,911,297.03	20,592,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,632,240.00	2,361,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,105,800.00	1,889,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	534,802.48	474,161.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,255,897.52	4,721,638.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,415,053.91	57,621,370.50
210301	Гэрэл, цахилгаан	11,056,303.91	14,577,868.00
210302	Түлш, халаалт	45,108,750.00	42,793,502.50
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,360,300.00	26,073,260.00
210401	Бичиг хэрэг	4,096,000.00	1,737,060.00
210402	Тээвэр, шатахуун	13,584,300.00	14,771,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,680,000.00	1,808,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,000,000.00	7,756,300.00
2105	Нормативт зардал	703,700.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	703,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,825,375.00	8,293,200.00
210604	Урсгал засвар	5,825,375.00	8,293,200.00
2107	Томилолт, зочны зардал	2,258,000.00	2,939,000.00
210702	Дотоод албан томилолт	2,258,000.00	2,939,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,453,948.00	42,308,756.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	45,941,948.00	40,797,353.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	399,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	399,978.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	280,000.00	280,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,802,887.63	208,508,268.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,802,887.63	208,508,268.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,037,693.00	87,183,698.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,037,693.00	87,183,698.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	7,343,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,037,700.00	11,282,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,999,993.00	68,557,998.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	99,192,533.13	128,837,278.23
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	64,993,555.00	78,371,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	64,993,555.00	78,371,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	64,993,555.00	78,371,900.00
220001	Барилга байгууламж	18,220,493.00	-
221001	Их засвар	846,000.00	-
223001	Бусад хөрөнгө	3,354,337.00	19,510,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,572,725.00	58,861,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	34,198,978.13	50,465,378.23
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,648,730.2	11,158,939,284.3	12,274,367,256.1
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	88,578.3	88,578.3
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.5	381,648,730.2	11,159,027,862.6	12,274,455,834.4
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,340,475,906.4)	(1,340,475,906.4)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,816,980,667.1	10,932,320,060.6
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,816,980,667.1	10,932,320,060.6
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,816,980,667.1	10,932,320,060.6
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(671,822,454.3)	(671,822,454.3)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,145,158,212.8	10,260,497,606.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	498,183,300.00	488,048,742.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	466,683,300.00	456,548,742.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	454,400,800.00	444,266,244.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,180,300.00	236,110,763.18
210101	Үндсэн цалин	184,146,900.00	179,920,037.07
210102	Нэмэгдэл	52,033,400.00	35,343,005.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	342,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,039,200.00	30,039,200.00
210201	Тэтгэврийн даатгал	20,592,000.00	20,592,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,361,900.00	2,361,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,889,500.00	1,889,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	472,300.00	472,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,723,500.00	4,723,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,466,000.00	57,621,370.50
210301	Гэрэл, цахилгаан	11,038,000.00	13,749,425.00
210302	Түлш, халаалт	48,178,000.00	43,621,945.50
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	25,038,200.00	22,791,860.00
210401	Бичиг хэрэг	1,450,000.00	1,737,060.00
210402	Тээвэр, шатахуун	11,888,200.00	11,489,600.00
210404	Ном, хэвлэл	-	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	7,146,200.00	7,146,200.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,033,400.00	41,214,400.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,521,400.00	39,702,997.38
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	399,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	399,978.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,509,000.00	46,403,450.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	999,998.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,500,000.00	31,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	-	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	493,183,300.00	493,183,300.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	2	2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-
650010	Гэрээт ажилтан	-	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	128,026,265.63	287,062,674.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	127,526,265.63	287,062,674.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	196,585,974.18
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,281,400.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,281,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,147,000.00
210604	Урсгал засвар	56,290,048.00	1,147,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,290,048.00	1,094,356.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,236,217.63	1,094,356.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,236,217.63	191,063,218.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	191,063,218.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	90,476,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	90,476,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	7,343,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	157,148,627.70	83,133,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,148,627.70	328,403,598.17
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,750,000.00	328,403,598.17
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,290,750.00	100,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,107,877.70	170,924,936.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		57,478,662.17

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар нь тайлант хугацаанд 25 орон тооны бүтэцтэй, Удирдах албан тушаалтан 3, гүйцэтгэх ажилтан 20, туслах ажилтан 2 орон тоотой ажиллаж байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Сүүлийн жилүүдэд иргэдийн аятай тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэн Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн компани 100%-ийн хөрөнгө оруулалтаар сумын төвийг төвлөрсөн халаалтын системд холбох, ТАХ, залуу гэр бүлийг хямд үнэтэй орон сууцаар хангах бодлогын хүрээнд 12 айлын “Хаус” хорооллын барилгын ажлыг эхлүүлэх, Улаанбаатар хоттой сумын төвийг засмал замаар холбосон, шинэ сууршлийн бүс болон захын хороололд 472 сая төгрөгийн эрчим хүчний сайжруулалт хийх, иргэнд газар өмчлүүлэхэд сумын үндсэн иргэдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж 4927 иргэнд 2,087.9 га газар өмчлүүлэх, “Эко тохилог хашаа” төслийг хэрэгжүүлэх, мах сүүний үйлдвэрүүдийг байгуулан ажиллуулж МАА-н гаралтай бүтээгдэхүүнийг сумандаа боловсруулж үйлдвэрлэж байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 бүлэг, 11 зорилт, 81 дэд зорилттой, хавсралт 1-ээр “Зохион байгуулах сургалтын төлөвлөгөө”, хавсралт 2-оор “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө”-г баталсан байна. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ тус байгууллага 79 ажлыг 100 хувь, 2 ажлыг 95 хувьтай гүйцэтгэсэн гэж дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 20 арга хэмжээг улирлаар төлөвлөн захиргаа, төсөв санхүү, албаны үйл ажиллагаанд хийж, 9 чиглэлээр зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг нь 5 хүний бүрэлдэхүүнтэй. Улирал бүр хяналт шалгалт хийж дүгнэлтийг Засаг даргын зөвлөлөөр оруулаж, зөвлөмжийг тоотоор хүргүүлэн ажилладаг. Санхүүгийн үйл ажиллагаанд 2 зөвлөмжийг өгч тухай бүр зөрчлийг арилгаж ажилласан байна.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тамгын даргын 2020 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн А/170 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. Энэхүү баримт бичигт төсвийн байгууллагын санхүү тайлагналын онцлогыг агуулсан бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 671,822.5 мянган төгрөгөөр буюу 6,1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	23,000.0	159,000.0	136,000.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	63,619.9	74,588.5	10,968.6
Үндсэн хөрөнгө	10,845,700.1	10,026,909.1	(818,791.0)
Нийт хөрөнгө	10,932,320.1	10,260,497.6	(671,822.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,932,320.1	10,260,497.6	(671,822.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,932,320.1	10,260,497.6	(671,822.5)

Авлага дансны эхний үлдэгдэлд булгийн эх хаших ажлын урьдчилгаа 14,000.0 мянган төгрөг, 10 га газарт хашаа барих ажлын урьдчилгаа /Эковишн ХХК/ 9,000.0 мянган төгрөгийн үлдэгдлээс 14,000.0 мянган төгрөгийн ажлыг хүлээн авч 9,000.0 мянган төгрөгийн ажлыг хүлээн аваагүй үлдэгдэлтэй байна. Тайлант онд сумын эрүүл мэндийн төвийн барилгын урьдчилгаа төлбөр 150,000.0 мянган төгрөг нэмэгдэж 159,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансны хувьд аж ахуйн материал 21,368,550.0 мянган төгрөг, мал амьтад 5,000,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад хангамжийн материал 15,400,000.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2022 онд барилга байгууламж, орон сууц 127,328.0 мянган төгрөг, тээврийн хэсэгсэл 194,079.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 38,365.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 7,622.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 25,042.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 127,328.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 194,079.0 мянган төгрөгийн тээврийн хэсэгсэл, 17,696.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,260,498.0 мянган төгрөг болж 671,823.0 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 504,918.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Засаг даргын тамгын газрын төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 496,683.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дүгээр сарын 16-ны 06 дугаар тогтоолоор баталсан. Тус байгууллагын төсөвт 1 удаа тодотгол хийж 498,183.3 мянган төгрөгөөр ирүүлсэн байна. Энэ нь үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлыг 288,114,9 мянган төгрөг, баг, хорооны үйл ажиллагааны арга хэмжээний зардлыг 54,997.0 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгэх арга хэмжээний зардлыг 45,779,9 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал 12,282.5 мянган төгрөг, Орон нутгийн нөөц хөрөнгө 5,000.0 мянган төгрөг, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал 39,509.0 мянган төгрөг, Хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх зардал 10,000.0 мянган төгрөг, Хөрөнгийн зардал 30,000.0 мянган төгрөг тус тус баталснаас хөрөнгийн зардалд 1,500.0 мянган төгрөгийг тодотголоор нэмэгдүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хүргүүлсэн дүнгээс бууруулан орон нутгийн төсвөөс 496,683.3 мянган төгрөгөөр батлан ирүүлснийг орон нутаг тодотгол хийсний дагуу 498,183.3 мянган төгрөгөөр Иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас баталсан байна. Тайлант оны батлагдсан төсвийг 1,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 498,183.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 498,183.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож 10,134.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 488,048.8 мянган төгрөг буюу 97,9 хувьтай байгаа нь цалин хөлсний зардал 1,887.9 мянган төгрөг, түлш халаалт 1,844.6 мянган төгрөг, томилолтын зардал 49.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,105.6 мянган төгрөг, хур хог хягдал зайлуулах зардлаас 2,243.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

		төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Үндсэн үйл ажиллагааны зардал	295,147.9	289,181	5,966.9	97.9
2	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	45,779.9	43,961.5	1,818.4	96
3	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Баг, хорооны ҮАЗардал	54,997.0	54,997.0	0	100
4	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-8080 Ажил олгогчоос олгох тэтгэмж	12,282.5	12,282.5	0	100
5	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Бусад	31,500.0	31,500.0	0	100
6	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0	100
7	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага-Баяр наадам	5,000.0	5,000.0	0	100
8	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага- 'Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	39,509.0	39,403.5	105.5	99.7
9	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага- 'Байгаль орчныг хамгаалах, нөхө	10,000.0	7,756.3	2,243.7	77.5
	Дүн	498,183.3	488,048.8	10,134.5	97.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд усны нөхөн төлбөр 1,671.8 мянган төгрөг, ХАА-н тооллого судалгааны санхүүжилт 4,940.9 мянган төгрөг, халдвар шүлхий өвчний шатахуун үнэ 1,555.2 мянган төгрөг, улс төрийн албан хаагчийн ажлаас чөлөөлөгдсөн тэтгэмж 6,343.2 мянган төгрөг, ЭМТ-ийн барилгын санхүүжилт 150,000.0 мянган төгрөг, үйл ажиллагааны үр дүнгийн болон тусламжийн орлого 5,126.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 12,353.9 мянган төгрөг, өвсний үнэ 14,666.8 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 29,122.3 мянган төгрөг, тэтгэлэг болон бусад

зардал 3,951.2 мянган төгрөг, улсын тэргүүний сумын шагнал 100,000.0 мянган төгрөг, нийт 329,731.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар тээвэр шатахуунд 3,281.4 мянган төгрөг, урсгал засвар 1,147.0 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээний зардал 1,094.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 188,321.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас 95,556.6 мянган төгрөг, нийт 289,400.67 мянган төгрөг зарцуулж, 40,330.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлагыг хангах	ОН-ын гүйцэтгэх засаглалын хөтөлбөр 98.2 %	449,707.3	441,922.0
2	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2022.01.01-2022.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хангах	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хангах хөтөлбөр 95,2%	49,509.0	47,159.8

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газар хөдөө аж ахуй, газар тариалан хариуцсан мэргэжилтний орон тоо бүтэц 31 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж 2 орон тоо дутуу байснаас шалтгаалсан байна. Орон тоо бүтэц дутуу ажилласан нь төрийн албаны ерөнхий шалгалтад тэнцсэн мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс шалтгаалжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 756,824.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,352.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,081.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ нь тайлант онд төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд түлш халаалт 1,844.6 мянган төгрөг, томилолтын зардал 49.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,105.6 мянган төгрөг, хур хог хягдал зайлуулах зардлаас 2,243.7 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 5.0 саяас дээших орлогын 19 гүйлгээ, зарлагын 23 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 21 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 5.0 сая төгрөгөөс дээш 19,647.4 мянган төгрөгийн 8 гүйлгээг нийт 63 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Энэ Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим"-ыг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж, байгууллагын мөрдөж ажилладаг хууль тогтоомжийн хэрэгжилт, ирсэн, явсан бичиг, даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж эрсдэлээ тодорхойлсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/64 дугаарын албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт 2 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	128,260.7	3	128,260.7	100
Зөвлөмж	1	585,609.7	1	585,609.7	100
Нийт дүн	4	713,970.4	4	713,970.4	100

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын бараа материалын бүртгэл, зарцуулалтыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 32,199.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.Үүнд:

Тус байгууллага тайлант онд ХААН банк дахь харилцах дансны орлого, зарлагын 7,049.1 мянган төгрөгийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нохой устгалын урьдчилгаа төлбөр 250.0 мянган төгрөгийг бүртгэхдээ бусад зардлын өглөг дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Досей ХХК-иар 19,500.0 мянган төгрөгөөр хийлгэсэн сургуулийн байрны зураг төсвийг орлогод авалгүй зардал дансанд бичиж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

“Хаус” хорооллын хүүхдийн тоглоомын үлдэгдэл төлбөр 5,400.0 мянган төгрөгийг төлөхдөө бусад зардлын тооцооны авлага дансанд бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 770,309.6 мянган төгрөгийн илэрсэн зөрчилд² 589,323.9 мянган төгрөгийн зөвлөмж, 180.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 180,805.7 мянган төгрөгийн албан шаардлага өглөө.

5.2 Төлбөрийн акт

Зэвсэгт хүчний ... дугаар ангийн албан хаагчийг төсвийн хөрөнгө 180.0 мянган төгрөгөөр шагнасан зөрчил илэрлээ. Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн 180,805.7 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд ...” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 589,323.9 мянган төгрөгийн өртгөтэй 1025 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцүүлж цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийг дахин үнэлж бүртгэлд тусгах, ашиглах боломжгүй үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант онд ХААН банк дахь харилцах дансны орлого, зарлагын 7,049.1 мянган төгрөгийг тайлагнаагүй байна	1	7,049.1	1	7,049.1			1	7049.1
Нохой устгал урьдчилгаа төлбөрийг бусад зардлын өглөг дансанд бүртгэсэн	1	250.0			1	250.0	1	250.0
Досей ХХК-иар сургуулийн байрны зураг төсвийг орлогод авалгүй зардал дансанд бичиж хаасан байна.	1	19,500.0			1	19,500.0	1	19,500.0
Хаус хорооллын хүүхдийн тоглоомын үлдэгдэл төлбөрийг төлөхдөө бусад зардлын тооцооны авлага дансанд бүртгэсэн	1	5,400.0			1	5,400.0	1	5,400.0
Дүн	4	32,199.1	1	7,049.1	3	25,150.0	4	32,199.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна.	180,805.7	-	180,805.7	-
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 589,324.0 мянган төгрөгийн өртгөтэй 1025 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	589,324.0	-	-	589,324.0
Зэвсэгт хүчний ... дугаар ангийн албан хаагчийг төсвийн хөрөнгөөр шагнасан байна.	180.0	180.0	-	-
Дүн	770,309.7	180.0	180,805.7	589,324.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Төв аймгийн Алтанбулаг сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 5.0 саяас дээших орлогын 19 гүйлгээ, зарлагын 23 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 21 гүйлгээг хугацаандаа байршуулахаас 5.0 сая төгрөгөөс дээш 19,647.4 мянган төгрөгийн 8 гүйлгээг нийт 63 мэдээллийг хугацаа хоцроосон байна	19,647.4	-	19,647.4	-